

11

**МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ЗАРИМ АСУУДАЛ**


Д. Пүрэв

Хүн капитал хувь хүнд байгаа орлого олох потенциалын үнэт чанарыг, тухайлбал хүний төрөлх авьяас, чадвар, тэрчлэн боловсрол, туршлагыг агуулж байдаг. Аж үйлдвэржсэн орнуудад дундаж ажилтны бүтээмж нь хөгжиж байгаа орнуудынхаас үлэмж илүү байна. Энэ нь хөгжингүй орнуудын ажиллагчид биет капиталыг үлэмж ашигладаг. Нөгөө талаар өндөр боловсрол болон мэргэжлийн сургалттай холбоотой.

Харин хөгжиж байгаа орнуудад орлогын доод түвшингийн үед үйлдвэрлэлийн хүчин зүйл, биет ба хүн капиталын хуримтлалын бүрдэлт үлэмж түвэгтэй байдаг. 80-аад оны байдлаар ажиллагсадын сургалтын дундаж хугацаа хөгжингүй орнуудад 9.6 жил, дундаж орлоготой орнуудад 4.8 жил, байхад буурай хөгжилтэй орнуудад 1.8 жил байна.

Боловсролын тогтолцоо нь технологийн хувьд Шинжлэх ухаан- сургалт болон үйлдвэрлэл гэсэн томоохон хоёр хэсэгт (Бүдүүвч 1) ангилагддаг.

Бүдүүвч 1



ШУ сургалт

Үйлдвэрлэл

- | | |
|----|----------------------------------|
| 1. | Академийн (үндсэн судалгаа) |
| 2. | Салбарын (хавсрага) судалгаа |
| 3. | Сургалт (ИТА бэлтгэх) |
| 4. | Шинжлэх ухаан техникийн мэдээлэл |
| 5. | Заводын судалгаа |

6. Төсөл боловсруулалт
7. Зохион бүтээх ажил
8. Туршилт тохируулга
9. Үйлдвэрлэл


Ингэж хуваах нь өмчийн олон хэлбэр хувь нийлүүлж, хөдөлмөрөө хорших үндсэн дээр үйлдвэрлэлийг томоохон цогцолбор болгох нөхцөл бүрдэнэ.

Хүнд зориулсан хөрөнгө оруулалт бол хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх чухал хэрэгсэл болдог. АНУ-д үндэсний бодит орлогын 32%-ийг хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлснээр, 68%-ийг хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлснээр хангадаг ажээ. Хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтийн 28%-ийг техникийн дэвшлээр, 19%-ийг хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлснээр, 14%-ийг боловсрол мэргэжлийг дээшлүүлснээр хангадаг байна.

Английн нэг сайн мэргэжилтнийг өөрийнхөө мэдэлд авч ажилуулахын тулд "Америкийн кодак" пүүс уг мэргэжилтний ажиллаж байсан Англи пүүсний бүх хувьцааг худалдаж аваад үйлдвэрийг нь хаачихжээ. Сингапурт XXI зууны "Оюуны удамшлын сан"-г одооноос байгуулж байна. Их сургуулийн ахлах ангиудаас онц, сайн сурлагатнуудыг тусгайлан шилж аваад "Ухаалаг сэхээтэн гэр бүл" болгохын тулд сургууль төгсөхөөс нь өмнө тэдэнд гэр бүл болоход нь улсаас материаллаг тусламж үзүүлдэг байна.

Ийнхүү дэлхийн хөгжлийн хандлагыг харахад хүнээ аль болох өндөр мэдлэгтэй, ялангуяа дээд боловсролтой болгохыг зорьж байна. Боловсролтой хүн аливаа асуудалд ухаалгаар ханддаг. Хөгжингүй орнуудад насанд хүрсэн хүн амын ихэнх дунд боловсролтой болсноор хязгаарлахгүй тэдгээрийн боловсролын түвшинг улам дээшлүүлж байдаг. Тухайлбал Японд дунд сургууль төгсөгчдийн 40%, Тайванд 20% нь их сургуульд орж байна. Монголд бичиг үсэг тайлагдалтын түвшин 1996 оны байдлаар 96.9 хувь байна. Харин ЮНЕСКО-гоос гаргасан аргачлалаар (6-23 насны хүнээр суурилж тооцсон) үзэхэд хүний хөгжлийн индекс 0.578 байгаа ажээ. Дэлхийд дээрх үзүүлэлт 0.8-аас их бол өндөр, 0.5-0.799 бол дунд, 0.5-аас бага бол хүний хөгжлийн доогуур үзүүлэлтэнд тооцогддог ажээ. Иймд Монгол хүний хөгжлийг индексээр тооцоход дэлхийн 100 орны ард орж байгаад анхаарах шаардлагатай. Үүний тулд манайд сургуулийн сурагчийн насыг 6-аас эхлэх хуулийн заалтыг хэрэгжүүлэх орчныг цаг алдалгүйгээр бүрдүүлэх нь зүйтэй. Тэрчлэн гурван наснаас нь сургуулийн өмнөх насны боловсрол олгох системд бүх хүүхдийг хамруулан, сургуулийн хүүхдийн насыг цаашдаа улам урагшлуулах ажлыг туршиж эхлэх, бэлтгэлийг материаллаг болон боловсон хүчнээр цаг алдалгүй хангах, улмаар бүрэн бус дундаас бүрэн дундад суралцагчдыг болон дээд сургуульд элсэгчдийг нэлээд нэмэгдүүлэх болон тэдний амьдрал, эрүүл ахуйн түвшинг үлэмж сайжруулах шаардлагатай. Орчин үед боловсролын систем нь боловсронгуй Япон, Герман, Америкийн загваруудыг судалж эрдэмтэд сүүлчийнхийг манайд илүү тохиромжтой гэж үздэг (бүдүүвч 2).

Дэлхийн ихэнх орны боловсролын тогтолцоо
(Америкийн Нэгдсэн Улсын жишгээр)



Тухайлбал, АНУ-д жилийн боловсролын дундаж зардал 26 тэрбум, ам. доллар байгаагаас 20% орчмыг авьяастай хүүхдүүдийг сургахад зарцуулдаг ажээ. Гэтэл Монгол улсад математик, физик, гадаад хэлний чиглэлээр төрөлжсөн хуруу дарам цөөхөн сургууль ажиллаж түүнд төр засгаас тавих анхаарал тусламж нэн доогуур учир сургалт нь 21 дүгээр зууны нийгмийн эрэлт хэрэгцээнээс үлэмж хоцорч байгаа нь илэрхий. Иймд хүүхдийн танин мэдэх сонирхлыг хөгжүүлж бие дааж боловсрол эзэмших арга барил төлөвшүүлэхэд чиглүүлэн төрөлжсөн цөөн хичээлийг заахаар Монголын сургалтын хөтөлбөрийг өөрчлөх хэрэгтэй. Тухайлбал, дэлхий дахины жишиг, зах зээлийн орнуудын туршлага, өөрийн орны онцлогт зохицуулан зайлшгүй анхан шатны боловсролыг эхний 6 жилд, дараагийн 2-3 жилд авьяас чадварыг илрүүлэх, амьдрал мэргэжлээ сонгох, сүүлийн 3 жилд авьяас сонирхолд тохирсон мэргэжил эзэмших буюу их, дээд сургуульд элсэх бэлтгэлийг хангах замаар тэднээс шалгаруулан колледж, их, дээд сургуульд оруулах. Тухайлбал, одоо үед манайд масс сургалт зонхилж буй учраас цаашдаа түүнээс элит болон төрөлжсөн сургалтанд шилжих чиг бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл шаардлагыг эн тэргүүнд хангах асуудал дэвшигдэж байна.

Дэлхийн ажиллагсадын мэдээлэл мэдлэгийн түвшинг 2 дахин нэмэгдүүлэхийн тулд

1900-1960 онд 60 жил

1960-1975 онд 15 жил

1975-1985 онд 10 жил

1985-1990 онд 5 жил тус тус шаардагдаж байжээ.

Дээрх судалгаанаас үзэхэд сургууль төгсөгчид мэргэжлээрээ 35 жил ажиллахын тулд эзэмшсэн мэргэжлээ 7 дахин сэлбэх буюу байнга суралцах шаардлагатай болж байна. Албан сургалтын үр ашигтай сургамжтай хэлбэрийн нэг нь хөгжилтэй орнуудын томоохон пүүсүүд өөрийнхөө шаардлага хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуультай байдаг байна. Жишээлбэл: Японы томоохон пүүсүүд 1-2 их сургуулийг харъяалж тэдгээрт өөрийнхөө ажилчдад тавих шаардлагыг урьдчилан хэвшүүлж ажиллах сурах орчныг адил болгох замаар хамтран ажиллаж зөвхөн тэндээс мэргэжилтнээ бэлтгэдэг журам Монголд ихээхэн сонирхол татаж байна. Үүний тулд Монголд мэргэжлийн (ахлах, дунд, дээд шатны) боловсрол эзэмшүүлэх талаар байнга мөрдөх нэгдсэн системийг нарийвчлан боловсруулах, тэрчлэн сургууль төгсөгчид мэргэжлээ 5-аас дээшгүй жилд байнга сэлбэж байх албан ба албан бус сургалтын журам бий болгож мөрдөх нь зүйтэй.

Зах зээлд шилжих шилжилтийн эхэн үеэс Монголд боловсролд зарцуулах хөрөнгийн хэмжээ үлэмж багасчээ. Хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцоход тэр нь 1997 онд 1991 оныхоос 68%-аар буурчээ. Өөрөөр хэлбэл, төсөвд ногдох боловсролын зардал 7.6%-аар багасчээ. 1995 онд төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг баталж боловсролыг улс нийгмийн тэргүүлэх салбар гэж тунхаглаад түүний санхүүжилтэд төсвийн жилийн орлогын 20-оос доошгүй хувийг зориулна гэж заажээ. Гэтэл 1997 онд энэ нь улсын төсвийн зарлагын 16% байгаад анхаарах нь зүйтэй.

Өндөр мэргэжилтэй боловсон хүчний тоог өсгөх эх үүсвэрийг нэмэгдүүлэх чухал чиглэл нь хувийн сургуулиудыг хөгжүүлэх асуудал юм. Монголд 1992-1994 онд мэргэжлийн сургуулиудад суралцагсдын тоо хорогдох хандлагатай байсан боловч өмчийн олон хэлбэрийн сургууль бий болсноор түүнд суралцагсдын тоо одоогоор 1980-1985 оны түвшинд хүрч нэмэгдлээ. Гэхдээ тэдгээрийн ихэнх нь хэлний болон нийгмийн ухааны чиглэлтэй өөрөөр хэлбэл, материаллаг бааз, хөрөнгө бага шаардагддаг салбарынх байна. Иймд цаашдаа хувийн их дээд сургууль коллежид ялангуяа, техникийн чиглэлийн их, дээд сургуульд суралцагсдын тоо эрс нэмэгдэх учир тэдгээрийн материаллаг баазыг чанаржуулж сургалтын чанарыг сайжруулахад онцлон анхаарах шаардлага дэвшигдэж байна.

Манай оронд ЕБС-ийн эхний 5-8 жилд сурагчдад ерөнхий боловсролоос гадна техникийн болон мэргэжлийн анхан шатны, дунд боловсрол төлөвшүүлэн олгох, харин 10 жилд бүрэн дунд боловсрол, техникийн болон мэргэжлийн дунд шатны мэргэжил олгож тэдэнд авьяас чадвараа илрүүлэн амьдрал хөдөлмөрт өөрийгөө бэлтгэхэд туслах зорилготой. Тэгэхдээ манайд ЕБС-ийн материаллаг бааз сургалтын арга зүйн талаар дутагдалтай багшлах боловсон хүчин хүрэлцээгүйгээс шалтгаалан хангалтгүй хэрэгжиж байгаад анхаарах нь зүйтэй. Монголд их дээд сургуульд элсэгчдийн тоо эрс хурдан өсөж, харин ТМС, ТМДС-ийнх үлэмж хорогдох хандлага байгаад онцлон анхаарч, улсын болон бүс нутгийн хэмжээгээр салбар, мэргэжил бүрээр дунд болон дээд боловсролтой мэргэжилтэй боловсон хүчний зохистой харьцааг бүрдүүлэхэд сургалтын бодлогыг чиглүүлэх шаардлагатай.

Зах зээлд шилжиж буй одоо үед сургалт төлбөртэй болсноор шалтгаалан ялангуяа, их, дээд сургуульд хүүхдээ элсүүлж сургахын тулд зах хязгаарын аймгийн хүн ам нийслэл болон томоохон хот, төвийн аймгууд руу шилжих үйл явц ихэсч байна.

Энэ нь хүн амын ялангуяа алслагдсан нутгийн хүн амын суурьшилд нөлөөлж байна. 1990-1998 онд Улаанбаатарт 69.7, Орхонд 25.0, Дархан Уул аймагт 13.3 мянган хүн тус тус шилжин ирсэн нь нийслэлийн хүн амын 10 гаруй, Орхоны хүн амын 30 гаруй, Дархан-Уул аймгийн хүн амын 15 хувьтай тэнцүү байна. Ийнхүү нийслэл хот, төв бүсийн бусад аймаг хотод шилжин суурьшигчдын бараг тэн хагас нь оюутан хүүхдээ аль нэг шатны сургуульд сургахын тулд нүүхээс өөр замгүй болдог ажээ. Ингэхлээр нэг талаар, залуучуудыг үйлдвэрлэлтэй танилцуулж тэднийг хөдөлмөр хийлгэх замаар амьдрах чадвараа дээшлүүлэхэд сургах, нөгөө талаар, хэрэгцээт хөрөнгийн эх үүсвэрээ бүрдүүлэхэд туслахын тулд тэднээр цалинтай ажил хийлгэх нь чухал ач холбогдолтой. Энэ чиглэлээр хөгжингүй орнууд үлэмж туршлага хуримтлуулжээ. Тухайлбал, АНУ-д 1980 онд ахлах ангийн хөвгүүдийн 54%, охидын 40% нь, харин одоо Японд нийт оюутны 90 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр хөдөлмөрлөж байна. Монголын төр засгаас залуусын дээд, тусгай, дунд мэргэжлийг эзэмшихтэй холбогдон бий болсон санхүү, эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн бэрхшээлийг даван туулахын тулд оюутнуудыг ажлын бус цагаар ажиллуулах ажил мэргэжлийн жагсаалт гаргаж, тэдэнд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.